



161

ХОНХОР ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 86 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/536, А/537, А/539, А/566 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтан сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажилтан сонгон шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар, шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурыг дөрөвдүгээр хавсралтаар, хонхор тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах журмыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Журам, хөтөлбөр, шалгуурыг мөрдөн ажиллахыг Хонхор тосгоны эрүүл мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд даалгасугай.

3. Дээрх тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Ө.ӨЛЗИЙПАГАМ




Хонхор тосгоны Эрүүл Мэндийн Төвийн
даргын 2025 оны 07-р сарын 01-өдрийн
А/кг тоот тушаалын 1 хавсралт



СОНГОН ШАЛГАРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Хонхор тосгоны эрүүл мэндийн төвийн дарга
Гишүүд: Хүний нөөцийн ажилтан
Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын
багийн ахлагч

Хонхор тосгоны Эрүүл Мэндийн Төвийн
даргын 2025 оны 04-р сарын 01-өдрийн
01.29 тоот тушаалын 2 хавсралт



АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийг үндэслэн ажилтан сонгон шалгаруулж авах үйл ажиллагаанд нэгдсэн стандарт тогтоох мэдлэг боловсрол мэргэжил, ур чадвар, туршлага бүхий ажил горилогчийг сонгон шалгаруулах замаар байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх, ажиллах хүчний тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Сонгон шалгаруулалт гэж тухайн ажлын байранд мэргэжил, боловсрол, ур чадвар, эрүүл мэндийн хувьд тохирох иргэдээс сонгох үйл ажиллагааг ойлгоно.

Хоёр. Бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт хийх үндсэн зарчим төрөл

2.1. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонголт хийхдээ дараах зарчмыг баримтлана.

- 2.1.1. Шударга
- 2.1.2. Хөндлөнгийн нөлөөнд үл автах
- 2.1.3. Ил тод, нээлттэй байх
- 2.1.4. Тэгш эрхийн зарчмаар хандах

2.2. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулахад үндэс угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах давуу байдал тогтоохыг хориглоно.

2.3. Сонгон шалгаруулалтыг дараах үе шатаар явуулах

- 2.3.1. Анкетын арга
- 2.3.2. Ярилцлагын арга
- 2.3.3. Мэргэжлийн болон мэдлэгийн шалгалт авах

Гурав. Хэрэгцээг тодорхойлох

3.1. Хэрэгцээг тодорхойлоход удирдлагын багийн саналыг авсны үндсэн дээр төлөвлөгөөнд тусган, шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг ажлын байрны захиалгын дагуу дараах тохиолдолд гаргана.

- 3.1.1. Шинээр ажлын байр бий болгох
- 3.1.2. Ажилтан тэтгэвэрт гарах ажлын байр
- 3.1.3. Жирэмсний болон амаржсаны амралт авах ажилтны ажлын байр

3.2. Сул орон тоог тухайн бүрт нь зарлах ба нэг ажил горилогч эдлэхгүй болно.

3.3. Ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх, жирэмсний амралт, өндөр насны тэтгэвэрт гарах, тахир дутуугийн групп тогтоолгох, суралцах зэрэг тохиолдол 1 сараас багагүй хугацаанд мэдэгдэж хүсэлт гаргана.

3.4. Ажилтан урт хугацааны чөлөө авах, эмнэлэгт хэвтэх, шинжилгээ өгөх зэрэг төлөвлөх болзошгүй бүрдүүлэх хэрэгцээг 1-3 хоногийн өмнө байгууллагад мэдэгдэж хүсэлт гаргана.

Дөрөв. Бүрдүүлэлт хийх

- 4.1. Хүний нөөцийн бүрдүүлэлт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
 - 4.1.1. Албан тушаалыг хооронд нь сэлгэх шилжүүлэх
 - 4.1.2. Их дээд сургууль төгсөгчдөөс
 - 4.1.3. Хөдөлмөр зуучлалын төв
 - 4.1.4. Бусад эх үүсвэрээс
- 4.2. Ажлаас ёс зүйн шаардлага зөрчсөний улмаас халагдсан ажилтныг эргүүлэн авах тохиолдолд тухайн чөлөөлсөн шалтгааныг харгалзан авах эсэх асуудлыг байгууллагын удирдлага болон сонгон шалгаруулалтын комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.3. Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн хүнийг ажил олгогчийн саналаар ажилд авах тохиолдолд шалгаруулалтыг мөрдөхгүй байж болно.

Тав. Сонгон шалгаруулалтанд хамрагдах иргэнд тавигдах шаардлага

- 5.1. Эрүүл мэндийн чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг улсын болон хувийн сургуулийг бакалавраас дээш боловсролтой төгссөн их эмч, тусгай мэргэжилтнүүд.
- 5.2. Тухайн зарлагдсан ажлын байранд бүртгүүлсэн болон бүртгэлтэй иргэд
- 5.3. Сонгон шалгаруулалтанд хамрагдах иргэдэд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд: Боловсролын бакалавр, магистраас дээш зэрэгтэй их, бага эмч сувилагч, тусгай мэргэжилтэй дипломтой, ажлын туршлагатай, мэргэжлийн зөвшөөрөлтэй байх.
- 5.4. Сонгон шалгаруулалтанд хамрагдсан иргэдэд дараах өвөрмөц шаардлага тавигдана. Үүнд: Англи хэлний анхан, дунд түвшнээс доошгүй мэдлэгтэй, компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн ашигладаг, интернетийн орчин дотоод сүлжээнд ажиллах, судалгааны талаар суралцсан, багаар ажиллах чадвартай, яриа харилцаа, хувийн соёл зохион байгуулалт сайтай, хууль эрх зүйн мэдлэгтэй байх.
- 5.5. Тусгай шаардлага: Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах, авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх.

Зургаа. Сонгон шалгаруулалт

- 6.1. Эмнэлэгт дутагдалтай байгаа болон чөлөөлөгдөх ажлын байрны захиалагыг нэгтгэн сонгон шалгаруулалтыг зарлуулна.
- 6.2. Нээлттэй ажлын байрыг байгууллагын цахим хуудас болон байгууллагын фэсбүүк группд болон бусад хэрэгслээр зарлаж, өргөдлөөр бүртгэнэ.
- 6.3. Сонгон шалгаруулалтанд оролцох иргэд дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд: Ажилд орохыг хүссэн өргөдөл, Мэргэжлийн сургууль төгссөн гэрчилгээ, диплом эмчлэх, сувилах, эх барих мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл мэргэжлийн зэрэг дэвийн үнэмлэх
- 6.4. Зарлагдсан ажлын байрны тодорхойлтонд заагдсан шаардлагыг хангаагүй мэргэжлийн үнэмлэх дипломгүй, бичиг баримт дутуу иргэдийн материалыг хүлээн авахгүй.

6.5. Сонгон шалгаруулалтын анкеттай танилцах, тест болон бичгээр шалгалт авах, ур чадварын сорил, авах ярилцлага хийх зэрэг хэлбэрээр зохион байгуулна.

6.6. Ерөнхий сорилын тестийг холбогдох мэргэжилтнүүд мэргэжлийн чиглэлийн дагуу боловсруулж, ерөнхий эмчээр баталгаажуулан сонгон шалгаруулах ажлын хэсэг мэргэжил, ёс зүй, онолын ерөнхий мэдлэгийн тестээр шалгалт авна. /шалгалтын нийт оноо 70 болон түүнээс дээш/

6.7. Сонгогдсон ажилтан нэмэлтээр дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд: Төрийн албан хаагчийн анкет, Иргэний үнэмлэх, 3-н үеийн намтар, цээж зураг, Худалдаа хөгжлийн банкны цалингийн карт, бичиг хэргийн хавтас.

Долоо. Хөдөлмөрийн гэрээ байгуулах

7.1. Сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажилтантай хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн хуулийн 24.1-д заасны дагуу байгуулна.

7.2. Хөдөлмөрийн гэрээг байгуулахдаа ажилтан болон байгууллагын хүлээх үүргийн уншуулж судлуулан хоёр талын төлөөлөл гарын үсгээр баталгаажуулна.

Найм. Дагалдах хугацаа

8.1. Сонгон шалгаруултанд тэнцсэн ажилтныг ажилд авахдаа эмнэлгийн ажиллагаатай танилцах, дасан зохицох, тухайн ажлын өвөрмөц шаардлага тэнцэх эсэхийг тодорхойлох зорилгоор 7-14 хоногийн хугацаагаар дагалдуулан ажиллуулна.

8.2. Энэ хугацаанд тухайн ажил горилогчийг цалингүй дагалдуулан ажиллуулна.

Ес. Хүлээх үүрэг хариуцлага

9.1. Сонгон шалгаруулах комиссын гишүүн, холбогдох мэргэжилтэн нь материалын нууцыг задруулах, оролцогчдод мэдээлэл өгөх, шан харамж авах, энэхүү журмын заалтуудыг илт зөрчсөн үйлдэл хийсэн нь тогтоогдвол байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.